



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/220

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1.“б”, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XII.6.1.4 дугаартай Боловсрол, соёлын салбарын байгууллагуудын тоног төхөөрөмж (Өвөрхангай)-д зарцуулах төсөл арга хэмжээний тухай Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/56 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Боловсрол, соёлын салбарын байгууллагуудын тоног төхөөрөмж (Өвөрхангай)-д зарцуулах 500,000,000 (таван зуун сая) төгрөгийн хөтөлбөр, арга хэмжээний зардлыг хавсралтаар баталсугай.

2.Хавсралтад тусгагдсан хөтөлбөр арга хэмжээг худалдан авах ажиллагааны дагуу зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100491

Аймгийн Засаг даргын 2020 оны 05 дүгээр сарын 05 ны өдрийн 05 дугаар захирамжийн хавсралт

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН ТӨСВИЙН БАГЦАД БАТЛАГДСАН XII.6.1.4 ХУУЛИЙН ДУГААРТАЙ ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАД ЭРХ ШИЛЖСЭН БОЛОВСРОЛ, СОЁЛЫН САЛБАРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ (ӨВӨРХАНГАЙ) ЗАРДЛЫН ХУВААРИЛАЛТ

№	Төсөл хөтөлбөр, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /мян төг/
1	Сумдын Соёлын төвийн үзэгчийн сандал, тавилга, тоног төхөөрөмж, /номын сан/	120.0
2	Сумдын Ерөнхий боловсролын сургуульд кабинет, тоног төхөөрөмж	248.0
3	Сумдын Ерөнхий боловсролын сургууль авто машин /3 ширхэг/	66.0
4	Сумдын цэцэрлэгийн тоглоом, тоног төхөөрөмж	42.0
5	Сумдын Ерөнхий боловсролын сургуулийн тоног төхөөрөмж, зөөлөн эдлэл	24.0
	НИЙТ ДҮН	500.0